ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дундговь аймгийн Дэлгэрцогт сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: ДУА-2023/08/НА-СТА-ТТЗ**

Аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Р.Мөнхтогтох
Утас: 70592439
Цахим хаяг: Munkhtogtokhr@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Наранцацрал
Утас: 70592225
Цахим хаяг: Narantsatsralkh@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Ихбаяр
Утас: 70593113
Цахим хаяг: Ikhbayard@audit.gov.mn

Цахим хуудас: www.audit.mn
Дундговь аймаг
2023 он

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Агуулга**


............ 0

1.Аудитын санал дүгнэлт ............ 2

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ............ 4

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ............ 4

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ............ 4

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ............ 5

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ............ 5

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ............ 6

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан ............ 7

3. Санхүүгийн тайлангийн тодруулга ............ 8

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа ............ 8

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин ............ 8

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ............ 8

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд ............ 8

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ............ 9

4. Аудитын тайлан ............ 11

4.1 Ерөнхий зүйл ............ 11

4.2 Материаллаг байдал ............ 11

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт ............ 12

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ............ 12

4.4.1 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ............ 12

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ............ 13

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал ............ 13

5. Аудитын илрүүлэлт ............ 13

6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл ............ 16


**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ИТХ | Иргэдийн төлөөлөгчдийн хурал |
| ЗДТГ | Засаг даргын тамгын газар |
| СХС | Сум хөгжүүлэх сан |
| ОНХС | Орон нутгийн хөгжлийн сан |
| БХС | Байгаль хамгаалах сан |
| МХС | Мал хамгаадах сан |
| ОННТ | Орон нутгийн нэгтгэсэн тайлан |

## 1.Аудитын санал дүгнэлт

**ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон, 7-р баг, Сайнцагаан сум Дундговь аймаг 48090 Утас: 70592439, 70592208, 70593208, Цахим хаяг: dundgovi@audit.gov.mn

2023.03.28 № 140

танай ................ -ний № ................ -т

ДУНДГОВЬ АЙМГИЙН ДЭЛГЭРЦОГТ СУМЫН ЗАСАГ ДАРГА М.БАЯРСҮХ ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-т заасны дагуу Дундговь аймгийн Дэлгэрцогт сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дундговь аймгийн Дэлгэрцогт сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад тайлант онд Дундговь аймгийн Дэлгэрцогт сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд 313.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг хүлээн авч, 2,140.0 сая төгрөгийн хөрөнгийг бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлж холбогдох хууль, журмын дагуу бүртгэл тайланд тусгасан байна. Уг үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Тус байгууллагын чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй бөгөөд үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй.

**Аудитын гол асуудал**

Дундговь аймгийн Дэлгэрцогт сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн Засаг даргын Тамгын газар нь аймгийн Засаг даргын 2022 оны Б/333 дугаар бүхий үндэслэлгүй захирамжаар төсвийн ерөнхийлөн захирагчид балансын урамшуулал олгосон, төсөл хэрэгжүүлэгч 2 иргэн үндсэн зээл, зээлийн хүү төлөөгүй, хугацаа хэтрүүлсэн зөрчил нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитаар материаллаг буруу тайлагналын эрсдэл өндөр үнэлэгдсэн асуудал байна.

**Бусад асуудлын хэсэг**

0012020273

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй зохистой гэж үзсэн.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 28 зорилт, 105 арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний үнэлгээгээр 99.0 хувийн гүйцэтгэлтэй тайлагнасан байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийллийг бүрмөсөн илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Р.МӨНХТОГТОХ

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан */мянган төгрөгөөр/*

| | | | |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **936,933.0** | **524,285.8** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | **189,022.6** | **226,706.1** |
| **33** | **АВЛАГА** | **386,290.4** | **116,487.1** |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **359,620.0** | **125,742.6** |
| 360 | БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ | 2,000.0 | 55,350.0 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 4,092,335.3 | 2,486,192.4 |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **4,092,335.3** | **2,486,192.4** |
| **39200** | **Биет хөрөнгө** | 4,005,978.6 | 2,451,039.8 |
| **39300** | **Биет бус хөрөнгө** | 86,356.7 | 35,152.7 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **5,029,268.3** | **3,010,478.3** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **6,962.8** | **681.1** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | **6,962.8** | **681.1** |
| **41300** | **Өглөг** | 6,962.8 | 681.1 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **5,022,305.5** | **3,009,797.2** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 5,022,305.5 | 3,009,797.2 |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал | 1,771,754.0 | 613,064.8 |
| 511002 | Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө | 1,771,754.0 | 613,064.8 |
| **51200** | **Хуримтлагдсан үр дүн** | 450,338.1 | 799,798.2 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 2,800,213.4 | 1,596,934.1 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **5,029,268.3** | **3,010,478.3** |

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан */мянган төгрөгөөр/*

| Код: | Тайлангийн үзүүлэлт | 2021оны 12-р сарын 31 | 2022 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **3,240,434.80** | **1,005,712.2** |
| **11** | **ТАТВАРЫН ОРЛОГО** | **68,855.20** | **196,269.8** |
| 110 | Орлогын албан татвар | 17,919.00 | 118,048.7 |
| 1100 | Хувь хүний орлогын албан татвар | 17,919.00 | 118,048.7 |
| 113 | Хөрөнгийн албан татвар | 41,660.20 | 61,572.0 |
| 118 | Бусад татвар, төлбөр, хураамж | 9,276.10 | 16,649.1 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 592,266.10 | 259,819.4 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 592,266.10 | 259,819.4 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **2,579,313.50** | **549,623.1** |
| **II** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **2,891,531.10** | **788,278.6** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,891,531.10** | **788,278.6** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **2,210,815.70** | **588,060.8** |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,082,635.20 | 235,635.2 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 139,688.10 | 28,760.4 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 127,707.80 | 36,443.6 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 110,703.40 | 34,491.9 |
| 2105 | Норматив зардал | 177,708.90 | 0 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 33,222.40 | 16,921.4 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 6,329.50 | 9,554.0 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 22,632.40 | 28,353.8 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 510,187.90 | 197,900.6 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **680,715.40** | **200,217.8** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **0** | **0** |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)** | **348,903.70** | **217,433.6** |
| **IV** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН** | **0** | **806.3** |
| **V** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | **77,590.70** | **2,013,996.8** |
| **VI** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)** | **271,313.00** | **-1,795,756.9** |

**2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан** */мянган төгрөгөөр/*

| Код: | Тайлангийн үзүүлэлт | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн | Нийт цэвэр хөрөнгө/өмч |
|---|---|---|---|
| **1** | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **4,742,034.8** | **4,742,034.8** |
| 2 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 8,957.7 | 8,957.7 |
| 3 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 4,750,992.5 | 4,750,992.5 |
| 9 | Тайлант үеийн үр дүн | 271,313.0 | 271,313.0 |
| **10** | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **5,022,305.5** | **5,022,305.5** |
| **11** | **2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **5,022,305.5** | **5,022,305.5** |
| 12 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | -226,341.4 | -226,341.4 |
| 13 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 4,795,964.0 | 4,795,964.0 |
| 19 | Тайлант үеийн үр дүн | -1,795,756.9 | -1,795,756.9 |
| **20** | **2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл** | **3,009,797.2** | **3,009,797.2** |

**2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан** */мянган төгрөгөөр/*

| Код: | Тайлангийн үзүүлэлт | 2021оны 12-р сарын 31 | 2022 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | **2,645,049.1** | **880,269.9** |
| **11** | **ТАТВАРЫН ОРЛОГО** | **68,855.2** | **196,269.8** |
| 110 | Орлогын албан татвар | 17,919.0 | 118,048.7 |
| 1100 | Хувь хүний орлогын албан татвар | 17,919.0 | 118,048.7 |
| 113 | Хөрөнгийн албан татвар | 41,660.2 | 61,572.0 |
| 118 | Бусад татвар, төлбөр, хураамж | 9,276.1 | 16,649.1 |
| 1180 | Бусад нийтлэг төлбөр, хураамж | 7,315.2 | 6,575.0 |
| 1181 | Газрын төлбөр | 1,910.9 | 10,074.0 |
| 1182 | Байгалийн нөөц ашигласны төлбөр | 50.0 | 0.0 |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **189,332.0** | **134,512.8** |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 189,332.0 | 134,512.8 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **2,386,861.9** | **549,487.3** |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **2,428,404.6** | **671,853.2** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,428,404.6** | **671,853.2** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,747,345.0** | **623,579.2** |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,085,700.1 | 272,385.1 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 139,726.1 | 33,332.7 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 127,787.4 | 150,063.4 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 64,929.3 | 29,356.7 |
| 2105 | Нормативт зардал | 97,350.2 | 0.0 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 48,746.5 | 20,511.3 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 6,329.5 | 9,554.0 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 22,361.0 | 28,301.6 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 154,414.8 | 80,074.4 |
| **211** | **ХҮҮ** | **0.0** | **0.0** |
| **212** | **ТАТААС** | **0.0** | **0.0** |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **681,059.6** | **48,274.0** |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)** | **216,644.5** | **208,416.7** |
| **V** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)** | **83,307.9** | **170,733.2** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **83,307.9** | **170,733.2** |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 83,307.9 | 170,733.2 |
| VI | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V) | -83,307.9 | -170,733.2 |
| VII | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН | -40,000.0 | 0.0 |
| 23 | ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ | 40,000.0 | 0.0 |

| | | | |
|---|---|---|---|
| **VIII** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)** | **93,336.5** | **37,683.5** |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 95,686.1 | 189,022.6 |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 189,022.6 | 226,706.1 |

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан** */мянган төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Төсвийн гүйцэтгэлийн тайлан |
|---|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **902,720.1** | **764,335.0** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **641,839.9** | **602,741.7** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **625,200.1** | **586,101.9** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **272,475.9** | **272,385.1** |
| 210101 | Үндсэн цалин | 206,526.1 | 206,410.1 |
| 210102 | Нэмэгдэл | 48,126.9 | 47,400.7 |
| 210104 | Урамшуулал | 17,822.9 | 18,574.3 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **34,169.8** | **33,332.7** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 23,309.5 | 22,960.4 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,742.5 | 2,725.2 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,180.6 | 2,166.8 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 539.9 | 482.2 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,397.3 | 4,998.1 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **149,789.7** | **149,355.4** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 15,192.0 | 14,777.8 |
| 210302 | Түлш, халаалт | 131,849.7 | 131,845.7 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 2,748.0 | 2,732.0 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **24,198.7** | **24,154.2** |
| 210401 | Бичиг хэрэг | 3,076.0 | 3,076.0 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 12,637.4 | 12,606.9 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,055.1 | 2,041.1 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 2,540.0 | 2,540.0 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,890.2 | 3,890.2 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **28,643.4** | **28,643.1** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 10,685.0 | 10,685.0 |
| 210604 | Урсгал засвар | 17,958.4 | 17,958.1 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 7,900.0 | 7,844.0 |
| 210702 | Дотоод албан томилолт | 7,900.0 | 7,844.0 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **14,779.2** | **14,563.1** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 12,190.9 | 12,181.0 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 320.9 | 320.8 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 197.4 | 197.4 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 45.0 | 45.0 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 720.0 | 720.0 |
| 210807 | Газрын төлбөр | 1,305.0 | 1,098.9 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **93,243.4** | **55,824.18** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 90,988.3 | 53,569.0 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,255.1 | 2,255.1 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **16,639.8** | **16,639.8** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 16,639.8 | 16,639.8 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 15,837.3 | 15,837.3 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 802.5 | 802.5 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **182,380.2** | **161,593.3** |
| 223001 | Бусад хөрөнгө | 182,380.2 | 161,593.3 |
| **23** | **ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ** | **78,500.0** | **0.0** |
| 230001 | Эргэж төлөгдөх зээл | 78,500.0 | 0.0 |
| **III** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **902,720.1** | **817,892.7** |
| **31** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **92,134.4** | **92,134.4** |

| | | | |
|---|---|---|---|
| 310001 | Улсын төсвөөс санхүүжих | 0.0 | 0.0 |
| 310004 | Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих | 92,134.4 | 92,134.4 |
| **32** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **635,017.1** | **624,987.8** |
| 320001 | Орон нутгийн төсвөөс | 635,017.1 | 624,987.8 |
| 320002 | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | 0.0 | 0.0 |
| **35** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | **175,568.6** | **100,770.6** |
| 350001 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 6,117.0 | 64,216.6 |
| 350002 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 34,641.2 | 36,554.0 |
| 350003 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 134,810.4 | 0.0 |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 0.0 | 143,468.1 |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 0.0 | 179,484.0 |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | **6** | **6** |
| 610001 | Төсвийн байгууллага | 6 | 6 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | **86** | **84** |
| 620001 | Удирдах ажилтан | 13 | 13 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 43 | 41 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 24 | 24 |
| 620004 | Гэрээт ажилтан | 6 | 6 |

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан** */мянган төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | ТЗ цэвэр дүн |
|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **53,074.8** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **53,074.8** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **46,617.0** |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **708.0** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 450.0 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 258.0 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **5,202.5** |
| 210401 | Бичиг хэрэг | 1,545.0 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,350.1 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 138.3 |
| 210404 | Ном, хэвлэл | 1,500.0 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 669.0 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **1,008.0** |
| 210604 | Урсгал засвар | 1,008.0 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **1,710.0** |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,710.0 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **13,738.4** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 13,640.1 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 98.0 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 0.3 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **24,250.2** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 24,070.2 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 180.0 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **6,457.8** |
| **2133** | **Олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **6,457.8** |
| 213403 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг | 6,386.8 |
| 213503 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг | 71.0 |
| **I** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **53,003.6** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **53,003.6** |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 18,736.0 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 14,058.9 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 20,208.6 |
| **III** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | **(71.3)** |

| | | |
|---|---|---|
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 71.4 |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 0.14 |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Дундговь аймгийн Дэлгэрцогт сумын Засаг дарга нь төрийн үйлчилгээний үйл ажиллагаа явуулдаг, Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллага юм.

Тухайн байгууллага эрхэм зорилгоо "Иргэддээ тулгуурласан чадвартай хариуцлагатай нутгийн өөрөө удирдах байгууллагыг төлөвшүүлэн хөгжүүлэх, сумын тогтвортой хөгжлийг хангах үйл ажиллагааны хөтөлбөрөө хэрэгжүүлэхэд нь Засаг даргад бүх талын дэмжлэг үзүүлэх гаргасан шийдвэрийнх нь биелэлтийг хангуулах нутгийн захиргааны манлайллыг дээшлүүлж иргэдэд төрийн үйлчилгээг хүргэх гүйцэтгэл үр дүнд чиглэсэн удирдлагын тогтолцоо бүхий тасралтгүй суралцагч цомхон чадварлаг алба байхад оршино" гэж тодорхойлжээ.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Тус байгууллага нь дотоод аудитын нэгж, хариуцсан ажилтангүй, дотоод аудитыг ТЕЗ-ийн харьяа Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас хэрэгжүүлсэн байна. Байгууллагын дотоод хяналтын зөвлөлд санхүүгийн мэргэжилтэй албан хаагч байхгүйгээс зөвхөн үндсэн. хөрөнгийн ашиглалт, хамгаалалтын эрсдэлийг л тооцож байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дундговь аймгийн Дэлгэрцогт сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Дундговь аймгийн Дэлгэрцогт сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дугаар тушаалаар баталсан "Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын Санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт орсон байна. Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүждэг байсан Ерөнхий боловсролын сургууль, Цэцэрлэг, Эрүүл мэндийн төв, орон нутгийн төсвөөс санхүүждэг байсан Соёлын төвүүд харьяалагдах яамдаасаа санхүүжилтээ авч, санхүүгийн тайлангаа яамдад нэгтгүүлдэг болсон. Нэгтгэлийн бодлогын өөрчлөлттэй холбоотой 2022 оны байгууллагуудын санхүүгийн тайланг орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн тайлангаас улсын төсвийн ерөнхийлөн захирагчид шилжүүлэн өгсөн байна. Дээрх байгууллагуудын

**байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлж, мөнгөн гүйлгээний тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд тайлагнасан байна.**

*3.4.1 Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

Дундговь аймгийн Дэлгэрцогт сумын Засаг даргын 2022 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2,018,790,0 мянган төгрөгөөр буюу 40.1 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт №1. /мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Эргэлтийн хөрөнгийн дүн | 936,933,0 | 524,285,8 | (412,647,2) |
| Мөнгөн хөрөнгө | 189,022,6 | 226,706,1 | 37,683,5 |
| Авлага | 386,290,4 | 116,487,1 | (269,803,3) |
| Бараа материал | 361,620,02 | 125,742,6 | (235,877,42) |
| Үндсэн хөрөнгө | 4,092,335,3 | 2,486,192,5 | (1,606,142,8) |
| **Нийт хөрөнгийн дүн** | **5,029,268,3** | **3,010,478,3** | **(2,018,790,0)** |
| Нийт өр төлбөр | 6,962,8 | 681,1 | (6,281,7) |
| Цэвэр хөрөнгө өмчийн дүн | 5,022,305,5 | 3,009,797,2 | (2,012,508,3) |
| **Өр төлбөр, цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **5,029,268,3** | **3,010,478,3** | **(2,018,790,0)** |

*Эх сурвалж: Санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 37,683,5 мянган төгрөгөөр өссөн нь Хоршоо хөгжүүлэх сангаас тайлант онд зарцуулалт хийгээгүйгээс шалтгаалсан байна.

Авлагын дансны үлдэгдэл 269,803,3 мянган төгрөгөөр буурсан нь Эрүүл мэндийн төвийн 192,451,6 мянган төгрөгийн ЭМД-ын сангаас авах цар тахлын дутуу санхүүжилт орж ирсэн, мөн Хоршоо хөгжүүлэх сангийн авлага 72,043,4 мянган төгрөгөөр буурсантай холбоотой байна.

Тайлант онд үндсэн хөрөнгийн дансанд төсвийн хөрөнгөөр 9,139,9 мянга, бусад эх үүсвэрээс 258,861,7 мянга, баланс хооронд 45,000,0 төгрөгийн хөрөнгө орлогод авч бүртгэсэн байна. Харин 228,645,8 мянган төгрөгийн хөрөнгө акталж, бүтцийн өөрчлөлтөөр 2,140,015,0 мянган төгрөгийн хөрөнгийг улсын төсөвт шилжүүлсэн байна. Энэ нь Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 3,009,797,2 мянган төгрөг болж 2,012,508,3 мянган төгрөгөөр буурахад нөлөөлжээ.

*3.4.2 Орлого бүрдүүлэлт*

Дундговь аймгийн Дэлгэрцогт сумын ИТХ-ын 2021 оны орон нутгийн төсөв батлах тухай 02 дугаар тогтоолоор Дэлгэрцогт сум тайлант онд 203,767.8 мянган төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 230,012.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 112.9 хувиар давуулан биелүүлсэн байна.

*Хүснэгт 2. Төвлөрүүлэх орлого* */мянган төгрөг/*

| Орлогын төрөл | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|
| Татварын орлого | | | | |
| Цалин хөлс түүнтэй адилтгах орлогоос суутгасан татвар | 82,400.0 | 95,345.0 | 12945 | 115.7 |
| Хувь хүний орлогын албан татвар | 11,500.0 | 20,963.8 | 9463.8 | 182.3 |
| Хөрөнгө борлуулсны орлого | | 1,740.0 | 1,740.0 | |
| Бууны албан татвар | 750.0 | 750.0 | 0 | 100.0 |
| Улсын тэмдэгтийн хураамж | 1,900.0 | 1,158.1 | -741.9 | 61.0 |
| Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр | 370.0 | 370.0 | 0 | 100.0 |
| Газрын төлбөр | 7,000.0 | 10,074.0 | 3074.0 | 143.9 |
| Хог хаягдлын үйлчилгээний хураамж | 4,000.0 | 5,046.9 | 1,046.9 | 126.2 |
| Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар | 2,000.0 | 2,929.8 | 929.8 | 146.5 |
| Малын тоо толгойн албан татвар | 63,452.8 | 57,892.2 | -5,560.6 | 91.2 |
| **Дүн** | **173,372.8** | **196,269.8** | **22,897.0** | |
| Татварын бус орлого | | | | |
| Хадгаламжийн хүүгийн орлого | 12,100.0 | 10,174.1 | (1,925.9) | 84.1 |
| Торгуулийн орлого | 18,000.0 | 23,478.1 | 5,478.1 | 130.4 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| Бусад орлого | 295.0 | 90.0 | (205.0) | 30.5 |
| **Дүн** | **30,395.0** | **33,742.2** | **3,347.2** | |
| **Нийт дүн** | **203,767.8** | **230,012.0** | **26,244.2** | **112.9** |

*Эх сурвалж: Санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Дараах орлогууд материаллаг дүнгээр давж биелсэн байна. Үүнд:

- Хувь хүний орлогын албан татварын орлого 9,463.8 мянган төгрөгөөр давж биелсэн нь энэ онд Соёлын төвийн барилга, цэвэр бохир усны байгууламж гээд суманд үйл ажиллагаа явуулсан байгууллагуудаас орлого орсонтой холбоотой.
- Газрын төлбөр 3,074.0 мянган төгрөгөөр давсан нь суманд дуудлага худалдаагаар шинэ газар авсан компаниас газрын төлбөр өндөр төлсөнтэй холбоотой.
- Хог хаягдлын хураамж 1,046.9 мянган төгрөгөөр давж биелсэн нь тайлант онд айл өрхийн хог хаягдлын хураамжийн тариф шинэчлэгдэж түүний дагуу орлого төвлөрүүлэлтийг хийгдсэнтэй холбоотой.
- Хөрөнгийн орлого 929.8 мянган төгрөгөөр давж биелсэн нь үл хөдлөх хөрөнгө болон хөрөнгө борлуулсны орлогыг илүү төвлөрүүлсэнтэй холбоотой.
- Торгуулийн орлого 5,478.1 мянган төгрөгөөр давсан нь засмал зам дагуу тээврийн хэрэгслийн хөдөлгөөн харьцангуй их байгаатай холбоотой байна.

Дараах нэр төрлийн орлого материаллаг дүнгээр тасарсан байна. Үүнд:

- Улсын тэмдэгтийн хураамж, малын тоо толгойн албан татвар, хадгаламжийн хүү болон бусад орлогын төлөвлөгөө 7,691.5 мянган төгрөгөөр тасарсан нь тухайн орлогын төлөвлөгөө хэт өндөр тавигдсан, хадгаламжийн хүү буурсан, орон нутагт хуулийн хэрэгжилт хангалтгүй байгаатай холбоотой байна.

Сумын 2022 оны татварын орлогын төлөвлөгөө нийт дүнгээрээ 112.9 хувиар давж биелсэн боловч 13 нэр төрлийн орлого төвлөрүүлэхээс 4 нэр төрлийн орлого 8,433.4 мянган төгрөгөөр тасарсан байна.

*3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв*

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Дэлгэрцогт сумын ИТХ-ын 2022 оны 17 дугаар тогтоолоор сумын төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны төсвийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,027,696.8 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1,027,696.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, баталсан байна.

Дэлгэрцогт сумын ИТХ-ын 2021 оны 02 дугаар тогтоолоор батлагдсан төсөвт 1 удаа өөрчлөлт хийж, зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зарлагыг тус бүр 124,976.7 мянган төгрөгөөр бууруулж 902,720.1 мянган төгрөгөөр баталсан байна.

Тус онд улсын төсөвт байгууллагуудын үйлчилгээний ажилчдын цалин орон нутгийн төсөвт батлагдсаныг 4 сараас хасаж улсын төсөвт шилжсэн, мөн ОНХС-ийн улсын төсвөөс олгох санхүүжилтийг бууруулж баталжээ.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд сумын Засаг даргын хэрэгжүүлэх 7 хөтөлбөрт зориулан 902,720,1 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 641,839.9 мянган төгрөгийг урсгал зардалд, 182,380.2 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд, 78,500,0 мянган төгрөгийг эргэж төлөгдөх зээлд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 92,134,4 мянган төгрөгийг улсын төсвөөс, 635,017,1 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 175,568.6 мянган төгрөгийг үндсэн болох туслах үйл ажиллагааны орлогоос, санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 92,134.4 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 624,987.8 мянган төгрөг, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос 100,770,6 мянган төгрөг, нийт 817,892,9 мянган төгрөгийн санхүүжилтийг авсан байна.

Үндсэн үйл ажиллагааны орлого 64,216,6 мянган төгрөгийг бүрдүүлж, батлагдсан төсвөөс 58,099.6 мянган төгрөгөөр буурсан нь зээлийн эргэн төлөлтөөс орсон мөнгө төлөвлөснөөс их орсон, туслах үйл ажиллагааны орлого 36,554.0 мянган төгрөгийг бүрдүүлж, батлагдсан төсвөөс 1,912.8 мянган төгрөгөөр буурсан байна.

Туслах үйл ажиллагааны орлогод Мал хамгаалах сангийн өвсний борлуулалтын орлого, төсөвт байгууллагуудын Ахмадын сангийн орлого ордог бөгөөд тайлант онд өвс тэжээлийн борлуулалт төлөвлөсөн хэмжээнд хийгдээгүйгээс туслах үйл ажиллагааны орлого тасарсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 764,335.1 мянган төгрөг буюу 84.7 хувьтай зарцуулсан байна.

Урсгал санхүүжилтээс дутуу зарцуулсан 1,719.0 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд хандив тусламжаар 18,736.0 мянган төгрөг, дээд шатны төсвийн захирагчаас 14,059.0 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 20,208.6 мянган төгрөг, нийт 53,303.6 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс: Байр ашиглалттай холбоотой зардалд 708.0 мянган төгрөг, хангамж бараа материалын зардалд 5,202.5 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардалд 1,008.0 мянган төгрөг, томилолтын зардалд 1,710.0 мянган төгрөг бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 13,738.4 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 24,250.2 мянган төгрөг, нийт 46,617.1 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 6,386.5 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" заасны дагуу Дундговь аймгийн Дэлгэрцогт сумын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг ахлах аудитор Д.Ихбаяр гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Наранцацрал, дарга, тэргүүлэх аудитор Р.Мөнхтоггох нар тус тус хэрэгжүүлсэн.

Дундговь аймгийн Дэлгэрцогт сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Дундговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 03 дугээр сарын 03-ны өдрийн 01/34 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нэгтгэсэн санхүүгийн тайлангаас нийт хөрөнгийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлангийн нийт хөрөнгө 3,010,478.3 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 30,104.8 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 21,073.3 мянган төгрөгөөр тогтоосон.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус тайланд нэгтгэгдсэн байгууллагуудын санхүүгийн тайланг түүвэрлэн шалгахад тус сумын Засаг даргын Тамгын газар нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийг 15 дугаар зүйлийн 15.1.3 дахь заалтыг зөрчин төсвөөс 838.1 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан зөрчил илэрч төлбөрийн акт тогтоосон.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 4 төрлийн мэдээллийг шилэн дансны цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Дундговь аймгийн Дэлгэрцогт сумын орон нутгийн төсөвт байгууллагууд төсвийн орлого, зарцуулалттай холбоотой мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд ил тод байршуулсан байна.

Харин шилэн дансанд байршуулбал зохих мэдээллийг бүрэн байршуулаагүй сумын Засаг даргын Тамгын газарт зөрчлийг арилгуулахаар хугацаатай албан шаардлага, Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд зөвлөмж хүргүүлсэн.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хэрэгжилтэд тусгайлсан аудит хийгдээгүй болно.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь сумын Засаг даргын Тамгын газар, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хувьд шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн байна гэж дүгнэлээ.

### 4.5 Зaвсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Дундговь аймгийн Дэлгэрцогт сумын төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй. Харин тус сумын Засаг даргын Тамгын газар, Орон нутгийн хөгжлийн сан, Байгаль хамгаалах сан, Мал хамгаалах, Сургууль, Цэцэрлэгийн санхүүгийн тайланд хийсэн завсрын аудитаар нийт 102,174.1 мянган төгрөгийн 26 алдаа зөрчил илэрч, 67,423.1 мянган төгрөгийн 10 алдааг аудитын явцад залруулсан, 837.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 23,461.9 мянган төгрөгийн 9 зөрчилд хугацаатай албан шаардлага, 10,451.9 мянган төгрөгийн 7 заалт бүхий зөвлөмжийг хүргүүлсэн байна. Жилийн эцсийн аудитаар алдаа зөрчлийн хэрэгжилт 100 хувьтай байна.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Дундговь аймгийн Дэлгэрцогт сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд шилэн дансны мэдээллийг хугацаа хоцроосон зөрчилд албан шаардлага хүргүүлж, санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн байгууллагуудын төсвийн шууд захирагч нарт 7,388.1 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 26,147.7 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 9 албан шаардлага хүргүүлсэн байна. Акт албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт дараах байдалтай байна.

| Үзүүлэлт | Өмнөх оны илрүүлэлт | | Биелэлт | | Биелэгдээгүй | | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Төлбөрийн акт | 1 | 7,388.1 | 1 | 7,388.1 | | | 100 |
| Албан шаардлага | 9 | 26,147.7 | 9 | 26,147.7 | | | 100 |
| Зөвлөмж | | | | | | | |
| Нийт | **10** | **33,535.8** | **10** | **33,535.8** | | | |

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан төсвийн байгууллагуудын бараа материалын зарцуулалтад дараагийн завсрын аудитаар горим, сорил хэрэгжүүлэхээр шийдвэрлэлээ.

## 5. Аудитын илрүүлэлт

*5.1 Сумын нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчилтэй асуудал*

Сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн аудитаар алдаа, зөрчилтэй асуудал илрээгүй.

*5.2 Сумын нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн төсвийн шууд захирагчдын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчилтэй асуудал*

Сумын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 2 төсвийн байгууллага, 4 тусгай сангийн нийт 6 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 1 байгууллагад дүгнэлт гаргаж, 5 байгууллага түүвэрт хамрагдсан байна.

Аудитад хамрагдсан Засаг даргын Тамгын газрын санхүүгийн тайланд "Өөрчлөлтгүй" санал дүгнэлт өгсөн байна.

*Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл:*

| № | Төсвийн захирагчийн ангилал | Байгууллага, нэгжийн тоо | | Санал дүгнэлтийн хэлбэр |
|---|---|---|---|---|
| | | Аудитад хамрагд | Үүнээс: Аудит хийсэн хэлбэр | |

| | | | Санал дүгнэлт гаргасан | Түүвэрт хамруулсан | Аудит хийгээгүй | Өөрчлөлтгүй | Хязгаарлалттай | Сөрөг | Дүгнэлт өгөхөөс татгалзсан |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| A | 1 | 2 | 3 | 4 | 5 | 7 | 8 | 9 | 10 |
| 1 | Засаг даргын Тамгын газар | 1 | 1 | | | 1 | | | |
| 2 | Иргэдийн Төлөөлөгчдийн хурал | 1 | | 1 | | | | | |
| 3 | Мал хамгаалах сан | 1 | | 1 | | | | | |
| 4 | Хоршоо хөгжүүлэх сан | 1 | | 1 | | | | | |
| 5 | Орон нутгийн хөгжлийн | 1 | | 1 | | | | | |
| 6 | Байгаль хамгаалах сан | 1 | | 1 | | | | | |
| | **НИЙТ** | 6 | 1 | 5 | | 1 | | | |

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 80,740.7 мянган төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 55,950.7 мянган төгрөгийн 5 алдааг аудитын явцад залруулж, 8,821.2 мянган төгрөгийн 3 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 5,804.3 мянган төгрөгийн 10 зөрчлийг арилгах албан шаардлага, 10,164.6 мянган төгрөгийн 3 заалт бүхий зөвлөмж хүргүүллээ.

Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчлийн 30.7 хувийг залруулагдаагүй, 69.3 хувийг залруулсан алдаа тус тус эзэлж байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл:**

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Дэлгэрцогт сумын ИТХ | 1 | 670.4 | 1 | 670.4 | | | 1 | 670.4 | | | | |
| Дэлгэрцогт сумын ЗДТГ | 2 | 280.3 | 1 | 20 | 1 | 260.3 | 2 | 280.3 | | | | |
| Дэлгэрцогт сумын СХС | | | | | | | | | | | | |
| Дэлгэрцогт сумын ОНХС | 2 | 55,000.0 | 1 | 10,000.0 | 1.0 | 45,000.0 | 2 | 55,000.0 | | | | |
| Дэлгэрцогт сумын БХС | | | | | | | | | | | | |
| Дэлгэрцогт сумын МХС | | | | | | | | | | | | |
| Дэлгэрцогт сумын ОННТ | | | | | | | | | | | | |
| **Дүн** | **5** | **55,950.7** | **3** | **10,690.4** | **2** | **45,260.3** | **5** | **55,950.7** | - | - | - | - |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл :**

| Байгууллагын нэр | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Дэлгэрцогт сумын ИТХ | 3 | 3,750.2 | | | 3 | 3,750.2 | | | | | | |
| Дэлгэрцогт сумын ЗДТГ | 6 | 1,986.6 | 1 | 837.3 | 4 | 1149.3 | 1 | | | | | |
| Дэлгэрцогт сумын СХС | 1 | 7,145.8 | 1 | 7,145.8 | | | | | | | | |
| Дэлгэрцогт сумын ОНХС | - | - | | | | | | | | | | |
| Дэлгэрцогт сумын БХС | 2 | 2,833.5 | | | 1 | 904.9 | 1 | 1928.6 | | | | |
| Дэлгэрцогт сумын МХС | 1 | 8,236.0 | | | | | 1 | 8,236.0 | | | | |
| Дэлгэрцогт сумын ОННТ | - | - | | | | | | | | | | |
| **Дүн** | **13** | **23,952.1** | **2** | **7,983.1** | **8** | **5,804.4** | **3** | **10,165** | - | - | - | - |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

| Байгууллгын нэр | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | | | | | |
| Дэлгэрцогт сумын ИТХ | 1 | - | | | 1 | | | | | | | |
| Дэлгэрцогт сумын ЗДТГ | 1 | - | | | 1 | | | | | | | |
| Дэлгэрцогт сумын СХС | - | - | | | | | | | | | | |
| Дэлгэрцогт сумын ОНХС | - | | | | | | | | | | | |
| Дэлгэрцогт сумын БХС | - | - | | | | | | | | | | |
| Дэлгэрцогт сумын МХС | - | - | | | | | | | | | | |
| Дэлгэрцогт сумын ОНПТ | - | - | | | | | | | | | | |
| **Дүн** | **2** | **-** | **-** | **-** | **2** | **-** | **-** | **-** | **-** | **-** | **-** | **-** |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | | | | | |
| Дэлгэрцогт сумын ИТХ | - | - | - | - | | - | | | | | | |
| Дэлгэрцогт сумын ЗДТГ | 1 | 838.1 | 1 | 838.1 | | | | | | | | |
| Дэлгэрцогт сумын СХС | - | - | | | | | | | | | | |
| Дэлгэрцогт сумын ОНХС | 1 | - | | | 1 | | | | | | | |
| Дэлгэрцогт сумын БХС | - | - | | | | | | | | | | |
| Дэлгэрцогт сумын МХС | - | - | | | | | | | | | | |
| Дэлгэрцогт сумын ОННТ | - | - | | | | | | | | | | |
| **Дүн** | **2** | **838.1** | **1** | **838.1** | **1** | **-** | **-** | **-** | **-** | **-** | **-** | **-** |
| **Нийт дүн** | **4** | **838.1** | **1** | **838.1** | **3** | **-** | **-** | **-** | **-** | **-** | **-** | **-** |